



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 133

Мандалговь

Хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.а, 3 дугаар зүйлийн 3.2.6.б, 5 дугаар зүйлийн 5.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Луус сумын ИТХ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8675.0 мянган төгрөгний анхны үнэ бүхий УАЗ-31512 маркын ДУА 2586 улсын дугаартай автомашиныг Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтэст балансаас баланст шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасахыг Луус сумын ИТХ-ын дарга Ш. Ойнборд, автомашиныг данс бүртгэлд холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэж авахыг Дундговь аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга С. Батчулуун нарт тус тус даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албанд үүрэг болгосугай.



ДАРГА

[Handwritten signature]
С. БУДЖАВ